



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/607

Алтай хот

Гэрээ шууд байгуулах эрх олгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх Есөнбулаг сумын 8 байршилд мод тарих ажлыг гэрээ шууд байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Болдбаатар)-т олгосугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан, гүйцэтгэгчийн ажлын хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Болдбаатар)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ Г.ЧИНБАТ